



**МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,  
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16  
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

2019.10.31 № 574953  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН  
ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН  
ТӨВ, АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА,  
ЗАХИРАГ НАРТ

Тушаал хүргүүлэх тухай

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулиас ирүүлсэн санал, хүсэлтийн дагуу Эрүүл мэндийн сайдын "Эрүүл мэндийн нийгмийн ажлтын ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загвар батлах тухай" 2018 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн А/289 дүгээр тушаалыг үүгээр хүргүүлж байна.

Энэхүү тушаалын дагуу эрүүл мэндийн нийгмийн ажлтын ажлын байрны тодорхойлолтыг өөрийн байгууллагад батлан мөрдүүлж, Монгол Улсын эрүүл мэндийн салбарт нийгэм-сэтгэл зүйн хэрэгцээнд тулгуурласан үйлчлүүлэгч төвтэй тусламж, үйлчилгээг хөгжүүлэх, олон нийтэд мэргэжлийн нийгмийн ажлын үйлчилгээг нэвтрүүлэхэд анхаарч ажиллана уу.

Хавсралт 6 хуудастай.

Хувийг:

1. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвүүд;
2. Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбоо;
3. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль;
4. Эрүүл мэндийн хөгжлийн төвд.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН ДАРГА

Б.ЦОДТБААТАР



089280



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2018 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/289

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн нийгмийн ажилтны  
ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн  
загвар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дах хэсэг, Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3.2 дах заалт, Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү загварын дагуу ажлын байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлэхийг эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Баярт/-т даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081189

Эрүүл мэндийн сайдын  
2018 оны 02 сарын 18 өдрийн  
А/х.39 дугаар тушаалын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН НИЙГМИЙН АЖИЛТНЫ АЖЛЫН БАЙРНЫ  
ТОДОРХОЙЛОЛТЫН ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

Дугаар .....

**А.Танилцуулга**

<b>1. Байгууллагын нэр</b> Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллага	<b>2. Нэгжийн нэр</b>	
<b>3. Ажлын байрны нэр</b> Эрүүл мэндийн нийгмийн ажилтан	<b>3.1 Албан тушаалын ангилал</b> Засгийн газрын тогтоолд зааснаар	<b>3.2 Албан тушаалын зэрэглэл</b> Засгийн газрын тогтоолд зааснаар
<b>4. Ажлын байрыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр</b> Удирдах ажилтан	<b>4.1 Албан тушаалын ангилал</b> Засгийн газрын тогтоолд зааснаар	<b>4.2 Албан тушаалын зэрэглэл</b> Засгийн газрын тогтоолд зааснаар
<b>5. Ажлын байрны шууд харьяалан удирдах албан тушаал</b>	<b>5.1 Албан тушаалын нэр</b>	<b>5.2 Албан тушаал эрхлэгчдийн тоо</b> /батлагдсан эрхлэгчдийн тооны дагуу/

**Б. Ажлын байрны чиг үүрэг**

<b>1. Ажлын байрны үндсэн зорилго</b>	Эрүүл мэндийн салбарт нийгэм-сэтгэл зүйн хэрэгцээнд тулгуурласан үйлчлүүлэгч төвтэй тусламж үйлчилгээг хөгжүүлэх, олон нийтийг чадавхжуулах, дэмжих орчин бүрдүүлэхэд чиглэсэн мэргэжлийн нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх
<b>2. Ажлын байрны үндсэн зорилт</b>	<p>I. Эрүүл мэндтэй холбоотой нийгэм-сэтгэл зүйн үйлчилгээг хувь хүн, гэр бүл, бүлэгт үзүүлэх</p> <p>II. Олон нийтэд чиглэсэн, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах</p> <p>III. Эрүүл мэндийн байгууллагын соёл, менежмент, зан үйл, ёс зүй, харилцааг дэмжсэн орчин бүрдүүлэх</p> <p>IV. Эрүүл мэндтэй холбоотой нийгэм сэтгэл зүйн хэрэгцээнд чиглэсэн судалгаа, эрдэм шинжилгээний ажил төлөвлөх, зохион байгуулах, үр дүнг тооцож ажиллах</p>
<b>3. Ажлын байрны гол үйл ажиллагаа</b>	Хугацаа, хуваарь

<p>3.1. <u>Ажлын байрны I үндсэн зорилтын хүрээнд:</u></p>	
<ul style="list-style-type: none"> <li>- Үйлчлүүлэгчийн нийгэм-сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг судлан, хэрэгцээ, давуу тал, нөөцөд тулгуурлан эрүүл мэндийн нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх, хүргэх, үнэлэх</li> </ul>	- Тогтмол
<ul style="list-style-type: none"> <li>- Эрсдэлт бүлгийн иргэдэд (нэн ядуу, хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настан, ХДХВ-ийн халдвартай хүмүүс, хүнд нөхцөлд байгаа хүүхэд, хүчирхийлэлд өртсөн хохирогч г.м.) эрүүл мэндийн нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай үйлчилгээнд холбох, зуучлах</li> </ul>	- Тогтмол
<ul style="list-style-type: none"> <li>- Эмнэлгийн хяналтад байдаг үйлчлүүлэгч (архинд донтсон сэтгэцийн эмгэгтэй г.м.), тэдний гэр бүлд нийгэм-сэтгэл зүйн тулгамдсан асуудлаа даван туулахад зөвлөгөө өгөх</li> </ul>	- Тогтмол
<ul style="list-style-type: none"> <li>- Үйлчлүүлэгчдийн дунд өвчний явц, хэлбэрээс хамааруулан нийгэм-сэтгэл зүйн асуудлыг (сэтгэл гутрал, сэтгэл түгшил, стресс, хөдөлгөөний идэвхийг дэмжих г.м.) даван туулахад чиглэсэн өөртөө туслах, дэмжих бүлэг зохион байгуулах, чиглүүлэх, идэвхжүүлэх</li> </ul>	- Тогтмол
<ul style="list-style-type: none"> <li>- Хамтарсан багийн үйл ажиллагаанд тогтмол оролцох, хамтран ажиллах, шаардлагатай үйлчлүүлэгчдэд үзүүлэх олон мэргэжлийн багийн тусламж үйлчилгээг зохион байгуулах</li> </ul>	- Тогтмол
<ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл мэндийн тулгамдсан асуудалтай үйлчлүүлэгч (хавдар, сүрьеэ, ХДХВ, ДОХ, архинд донтох г.м.)-ийн тулгамдсан нийгэм сэтгэл зүйн асуудлыг шийдвэрлэх, зан үйлийг өөрчлөх, эрүүл зан үйл төлөвшүүлэх зорилгоор заслын, дэмжих, өөртөө туслах бүлэг ажиллуулах</li> </ul>	- Тогтмол
<p>3.2. <u>Ажлын байрны II үндсэн зорилтын хүрээнд:</u></p>	
<ul style="list-style-type: none"> <li>- Зорилтот бүлгийн (ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, эмзэг бүлгийн иргэд г.м.) хүн амд чиглэсэн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр, стратегийн хүрээнд төлөвлөлт хийх, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах, үнэлэх</li> </ul>	- Тогтмол
<ul style="list-style-type: none"> <li>- Зорилтот бүлгийн хүн амд чиглэсэн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр, стратегийг хэрэгжүүлэхэд эрүүл мэндийн бусад ажилтантай баг бүрдүүлж, хамтран ажиллах, эрүүл мэнд, нийгмийн халамж, нийгэм сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх</li> </ul>	- Тогтмол
<ul style="list-style-type: none"> <li>- Зорилтот бүлэг болон орон нутгийн өвөрмөц хэрэгцээ, онцлогт тохирсон төсөл, хөтөлбөрийг санаачлах, боловсруулах, хэрэгжүүлэх</li> </ul>	- Тухай бүр
<ul style="list-style-type: none"> <li>- Хүн амын дунд эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх үйл ажиллагааг олон нийтэд хүртээмжтэй, шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулах</li> </ul>	- Тогтмол
<ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл мэндийн сайн дурын идэвхтэн, үе тэнгийн сургагч багш бэлтгэх, мэргэжлийн удирдлага арга зүйгээр хангаж, хамтран ажиллах</li> </ul>	- Тогтмол
<ul style="list-style-type: none"> <li>- Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэнтэй хамтран хүн амын дунд эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах</li> </ul>	- Тогтмол

<p><b>3.3. Ажлын байрны III үндсэн зорилтын хүрээнд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Байгууллагын соёл, зан үйл, ёс зүй, харилцаа хандлага төлөвшүүлэх чиглэлийн үйл ажиллагаа зохион байгуулах</li> <li>- Эрүүл мэндийн ажилтны дунд ажлын байрны стресс, дарамт, ажлаас халшрах хам шинж зэрэг нийгэм-сэтгэл зүйн асуудлыг тодорхойлох, үнэлэх, зөвлөгөө өгөх</li> <li>- Эрүүл мэндийн ажилтнуудад үйлчлүүлэгчдийн нийгэм-сэтгэл зүйн асуудлын талаарх мэдлэг олгох, хандлага төлөвшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах</li> <li>- Үйлчлүүлэгч төвтэй нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх орчин нөхцөл бүрдүүлэх талаар санал дэвшүүлэх, хамтран ажиллах</li> </ul>		- Тухай бүр	
<p><b>3.4. Ажлын байрны IV үндсэн зорилтын хүрээнд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй зан үйл, нийгэм-сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг судлах, шаардлагатай хөтөлбөр арга хэмжээ, үйлчилгээг тодорхойлох</li> <li>- Эрсдэлт болон зорилтот бүлгийн хүн амын дунд тулгамдаж буй эрүүл мэнд, нийгмийн асуудлыг илрүүлэх, шаардлагатай үйлчилгээний хэрэгцээг тодорхойлох</li> <li>- Нотолгоонд тулгуурласан эрүүл мэндийн нийгмийн ажлын үйлчилгээг практикт нэвтрүүлэх</li> <li>- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн судалгаа хийх</li> </ul>		- Тухай бүр	
<p><b>3.5 Бусад</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй хууль, дүрэм, дотоод журмыг мөрдөж ажиллах</li> <li>- Мэргэжлийн ур чадвар, мэдлэг боловсролоо тасралтгүй дээшлүүлж, мэргэжлийн ёс зүй, хэм хэмжээг чанд мөрдөж ажиллах</li> <li>- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах</li> </ul>		- Тогтмол	
		- Тогтмол	
		- Тогтмол	

**В. Тавигдах шаардлага**

1. Ажлын байранд тавигдах ерөнхий	Мэргэжлийн ур чадвар	Үзүүлэлт	Зайлшгүй шаардлагатай	Шаардлагатай		
		Боловсрол	Эрүүл мэндийн нийгмийн ажилтан эсхүл нийгмийн ажилтны бакалаврын зэрэг	Магистр ба түүнээс дээш зэрэгтэй		
		Мэргэжил	Эрүүл мэндийн нийгмийн ажилтан			
		Мэргэшил		- Эрүүл мэндийн ажилтны чиглэлээр мэргэшлийн сургалтанд хамрагдсан үнэмлэх - Эрүүл мэндийн ажилтны магистр зэрэгтэй байх		
		Туршлага		- Мэргэжлээрээ ажилласан	дадлага	

		<ul style="list-style-type: none"> <li>- Хэрэгцээг судлах, нөхцөл байдлын үнэлгээ хийх</li> <li>- Шаардлагатай үйлчилгээг төлөвлөх, хүргэх, хяналт тавих</li> <li>- Харилцааны ур чадвартай байх</li> <li>- Нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө өгөх</li> <li>- Олон мэргэжлийн багаар ажиллах</li> <li>- Хүн амын дунд эрүүл зан үйл төлөвшүүлэх</li> <li>- Олон нийтийн давуу тал нөөц боломжийг илрүүлэх</li> <li>- Нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах</li> <li>- Нийгмийн судалгааны аргазүй эзэмшсэн байх</li> <li>- Мэргэжлийн удирдлагаар хангах</li> </ul>	туршлагатай байх - Асуудалд шинжилгээ хийх - Манлайлах, нөлөөлөх, сургах	дүн
	Ур чадвар			
	Тусгай шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>- Мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, дүрэм, журмыг сахин ажиллах</li> <li>- Байгууллагын болон хувь хүний нууцыг хадгалах</li> <li>- Авлигаас ангид байж, авлигын эсрэг хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөн ажиллах</li> <li>- Сонирхлын зөрчлөөс ангид байх</li> </ul>		

**Г. Хүчин зүйлс:**

1. Ажлын байрны харилцах субъект			
1.1 Байгууллагын дотор талд:		1.2 Байгууллагын гадна талд:	
<ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл мэндийн байгууллагын дарга</li> <li>- Орлогч дарга, алба, тасаг, нэгжийн дарга, эрхлэгч,</li> <li>- Эрүүл мэндийн бусад ажилтан</li> </ul>		<ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл мэндийн яам, холбогдох газар</li> <li>- Эрүүл мэндийн бусад байгууллага</li> <li>- Мэргэжлийн байгууллага, нийгэмлэг, холбоо</li> <li>- Төрийн болон төрийн бус болон бусад байгууллага</li> <li>- Үйлчлүүлэгч, түүний гэр бүл, асран хамгаалагч, харгалзан дэмжигч г.м</li> </ul>	
2. Албан тушаал эрхлэгчийн хүлээх хариуцлага	Ажлын байрны үндсэн чиг үүрэгт заасан үйл ажиллагаатай холбоотой асуудлыг байгууллагын удирдах ажилтан холбогдох алба, тасаг, нэгжийн дарга, эрхлэгчийн өмнө хариуцна.		
3. Ажлын байрны нөөц хэрэгсэл	3.1 Санхүүгийн	<ul style="list-style-type: none"> <li>- Үндсэн цалинг Засгийн газрын тогтоолын дагуу тооцож олгох</li> <li>- Хууль тогтоомжийн дагуу нэмэгдэл, бусад нэмэгдэл, урамшуулал олгох</li> </ul>	
	3.2 Материалын	<ul style="list-style-type: none"> <li>- Мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай өрөө</li> <li>- Компьютер, дагалдах хэрэгслийн хамт</li> </ul>	

		<ul style="list-style-type: none"> <li>- Ажлын хувцас</li> <li>- Бичгийн хэрэгсэл</li> <li>- Дотуур холбоо, дотоод сүлжээ</li> <li>- Бусад шаардлагатай хэрэгсэл</li> </ul>	
	3.3 Хүний		
	3.4 Бусад	- Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд жил бүр үнэ төлбөргүй хамрагдах	
4. Ажлын байрны нөхцөл	4.1 Хэвийн нөхцөл	Ердийн	
	4.2 Онцгой нөхцөл		

#### Д. Баталгаажуулалт

Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан	Ажлын байрны тодорхойлолтыг баталсан
<p>.....</p> <p>(Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан албан тушаалтны эцэг, эхийн нэрний эхний үсэг, өөрийн нэр)</p> <p>.....</p> <p style="text-align: center;">(гарын үсэг)</p> <p>..... оны ... дугаар сарын ... -ны өдөр</p>	<p>.....</p> <p>(Ажлын байрны тодорхойлолтыг баталсан албан тушаалтны эцэг, эхийн нэрний эхний үсэг, өөрийн нэр)</p> <p>.....</p> <p style="text-align: center;">(гарын үсэг)</p> <p>..... оны ... дугаар сарын ... -ны өдөр</p>



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМАНД

**АШУУИС** | НИЙГМИЙН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН СУРГУУЛЬ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
С.Зоригийн гудамж, Шуудангийн хайрцаг 48/111  
Утас: 976-11-329126

2019.09.25 № 1/159  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Санал хүргүүлэх тухай

Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль нь 2003 оноос эрүүл мэндийн нийгмийн ажилтан бэлтгэж эхэлсэн бөгөөд төгссөн нийт 253 мэргэжилтний 93.6 хувь нь Монгол улсын эрүүл мэндийн салбарт ажиллаж байна.

Эрүүл мэндийн сайдын 2018 оны 07 сарын 18-ний А/289 дугаар тушаалаар эрүүл мэндийн нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолт батлагдсанаар тус мэргэжлийг Монгол улсын үндэсний ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолтод тусгах боломж бүрдсэн юм. Иймд эрүүл мэндийн нийгмийн ажилтан мэргэжлийг тус ангилал, тодорхойлолтод тусгах хүсэлтийг ажлын байрны тодорхойлолтын хамт Нийгмийн Хамгаалал Хөдөлмөрийн Яаманд хүргүүлж, дэмжлэг үзүүлнэ үү.

2) Мөн эрүүл мэндийн нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолтыг ЭМЯ-ны харьяа байгууллагуудад хүргүүлж өгнө үү.

Дэмжиж ажиллаж буй та бүхэнд баярлалаа.

ЗАХИРАЛ



Д.ДАВААЛХАМ